# ТАЙЛАН

“Эрдэнэс Газ” ХХК-ийн 2026 оны эхний хагас жилийн үйл ажиллагаа, батлагдсан төсөв, бизнес төлөвлөгөө болон 25 арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг толгой компанид танилцуулж, хоёрдугаар хагас жилийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход оршино.

Тайлант хугацаа ба үе шат:

Тайлант хугацаа нь 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх үеийг хамрах бөгөөд үйл ажиллагааг дараах хоёр үе шатанд хуваан хэрэгжүүлсэн болно:

- Өөрчлөн байгуулалтын өмнөх үе (2026.01.01-2026.02.25): “Эрдэнэс Ашид” ХХК болон “Эрдэнэс Газ” төслийн нэгж нь тус тусдаа бие даан үйл ажиллагаа явуулж байсан.

- Өөрчлөн байгуулалтын дараах үе (2026.02.26-2026.06.30): Шинэ бүтэц, бүрэлдэхүүн, удирдлага болон шинэчлэгдсэн чиг үүргийн дагуу үйл ажиллагааг явуулсан.

Тайлагнах арга зүй ба хязгаарлалт:

Тайлангийн тоон болон чанарын үзүүлэлтийг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болгон 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш хийгдсэн ажлуудыг эхний хагас жилийн гүйцэтгэлд хамруулалгүйгээр, хоёрдугаар хагас жилийн арга хэмжээний хэсэгт тусад нь тусгав.

Батлагдсан 25 арга хэмжээний нэгдүгээр ба хоёрдугаар улирлын төлөвлөлт, тэдгээрийн хүрэх үр дүнгийн биелэлтийг тогтоосон ач холбогдлын хувиар тооцож, зорилт тус бүрийн биелэлтийг гаргасан. Түүнчлэн төлөвлөгөөний 8 зорилтын хувьд хоорондын ач холбогдлын эрэмбэ тусгайлан тогтоогдоогүй тул бүгдийг ижил түвшний ач холбогдолтой гэж үзэн нэгдсэн гүйцэтгэлийг тодорхойлов.

Компанийн дүрэмд олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар заагаагүй бөгөөд тайлант хугацаанд барилга угсралтын ажил эхлээгүй, үндсэн үйл ажиллагааны орлого бүрдүүлээгүй болно. Иймд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээ болон нөхөн сэргээлтийн үзүүлэлтүүд энэхүү тайланд хамаарахгүй болно.

# ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАЛТ, ЭРХ ЗАЛГАМЖЛАЛ, ЗАСАГЛАЛ

## Хүснэгт 2. Эрх зүйн болон өөрчлөн байгуулалтын он дараалал

| Огноо | Үйл явдал | Баримт / үр дүн |
|---|---|---|
| 2026.02.11 | Засгийн газрын хурлаар “Эрдэнэс Ашид” ХХК-ийн нэрийг өөрчилж, төслийн нэгжийг нэгтгэх, дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг батлуулах, улсын бүртгэлд бүртгүүлэхийг даалгав | Засгийн газрын 54 дүгээр тогтоол |
| 2026.02.26 | ТУЗ-ийн хурлаар компанийн нэрийг “Эрдэнэс Газ” ХХК болгон өөрчилж, дүрмийг шинэчлэн баталж, орон тооны хязгаарыг 45 болгож, бүтцийг баталж, төслийн нэгжийг нэгтгэх шийдвэр гаргаж, хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэв | ТУЗ-ийн 06 дугаар тогтоол |
| 2026.02.26 | Компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчийг томилсон | Хувьцаа эзэмшигчийн А/33 дугаар тушаал |
| 2026.03.02 | Гүйцэтгэх удирдлагын өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэв. | Улсын бүртгэлийн бүртгэл |
| 2026.03.10 | Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинэчлэн гаргуулав. | Улсын бүртгэлийн гэрчилгээ |
| 2026.03.20 | Үндсэн чиг үүрэг, бүтэц, орон тооны хязгаар шинэчлэгдсэнтэй холбогдуулан бөөнөөр халах хөдөлмөрийн эрх зүйн харилцаа үүсэж, хэлэлцээр хийх ажлын хэсэг томилогдсон | Гүйцэтгэх захирлын тушаал |
| 2026.03.31-04.20 | Албан хаагчдын төлөөлөлтэй 3 удаагийн уулзалт зохион байгуулж, холбогдох тэтгэмж, цалин хөлс, ээлжийн амралтын мөнгө болон нийгмийн даатгалын шимтгэлийг хууль тогтоомжийн дагуу бүрэн барагдуулсан | Хэлэлцээрийн тэмдэглэл |
| 2026.04.13 | ТУЗ-ийн Аудитын хорооны хурлаар 2026 оны төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг танилцуулсан | Хорооны дүгнэлт, зөвлөмж |
| 2026.04.14 | ТУЗ-ийн ээлжит хурлаар 2026 оны төсөв, бизнес төлөвлөгөөг баталсан | ТУЗ-ийн 24 дүгээр тогтоол |
| 2026.04.21 | Компанийн 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, цахим системд байршуулав | Гүйцэтгэх захирлын А/06 тушаал |
| 2026.04.24 | Хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулсан | Хурлын шийдвэр, тэмдэглэл |

## Эрх залгамжлал, нэгтгэл

Өмнө нь “Эрдэнэс Ашид” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгө улсын бүртгэлд албан ёсоор бүртгэлтэй байсан бол “Эрдэнэс Газ” төслийн нэгж нь улсын бүртгэлд бүртгэлгүй, зөвхөн Татварын ерөнхий газарт бүртгэлтэй байсан. Иймд хоёр байгууллагыг нэгтгэх гэрээг үндэслэн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг эхлүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 06 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж дараах арга хэмжээг шуурхай зохион байгууллаа:

- Төслийн нэгжийн орон тоо, албан хаагчдыг компанид шилжүүлэх;
- Өмнө байгуулсан гэрээ, хэлэлцээр болон хүлээсэн эрх, үүрэг, хариуцлага, архивын баримт бичгүүдийг бүрэн шилжүүлж авах;

- Улсын бүртгэл, нийгмийн даатгал, татвар болон санхүүгийн байгууллагуудад холбогдох бүртгэл, өөрчлөлт, хасалтын арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллав.

Үүний үр дүнд хүний нөөцийн шилжилт болон байгууллагын албан ёсны бүртгэлийн үйл ажиллагаа амжилттай хэрэгжсэн болно.

## Засаглалын онцлог

Компани нь бие даасан Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-гүй бөгөөд бизнес төлөвлөгөө, төсөв болон засаглалын гол шийдвэрийг толгой компанийн ТУЗ баталдаг бөгөөд тогтоолын хэрэгжилтэд ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын газар хяналт тавьж ажилладаг.

Энэхүү засаглалын онцлог нь шийдвэр гаргах хугацаа болон үйл ажиллагааны цаглаварт шууд нөлөөлж байна. Тухайлбал, 2026 оны төсөв, бизнес төлөвлөгөөг ТУЗ-ийн 06 дугаар тогтоолоор 2026 оны 03 дугаар сард багтаан хэлэлцүүлж батлуулахаар заасан хэдий ч бодит байдал дээр 2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан юм. Үүний улмаас төлөвлөгдсөн 25 арга хэмжээний I улирлын гүйцэтгэлийг батлагдсан төлөвлөгөөтэй уялдагдуулан хэмжих боломжгүй байсан бөгөөд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө нь II улирлын сүүлийн 10 долоо хоногт шилжиж батлагдах нөхцөл үүссэн байна.

## Сургалт

Компанийн 2026 оны сургалтын төлөвлөгөөний хүрээнд ажилтан, албан хаагчдыг нийт 7 удаагийн сургалт, семинарт хамруулсан. Үүнд:

2026.05.06: Архивын ерөнхий газраас зохион байгуулсан “Бичиг баримтын стандарт болон хадгаламжийн нэгж бүрдүүлэх” сургалт;

2026.05.08: "Эрдэнэс Монгол" ХХК-аас зохион байгуулсан "Нэгдлийн төслийн удирдлагын тогтолцооны талаар мэдээлэл өгч танилцуулга хийх" үйл ажиллагаа;

2026.05.21 болон 2026.06.16: Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтууд;

2026.05.22: "Эрдэнэс Монгол" ХХК-аас зохион байгуулсан “Хэвлэл мэдээлэл, олон нийтийн уулзалт” семинар;

2026.06.03: Стратегийн судалгааны хүрээлэнгээс зохион байгуулагдсан "Монгол-Орос-Хятадын Эдийн Засгийн Коридор: сорилт, боломж, шийдэл" гурван талт бага хурал;

2026.06.26: "Эрдэнэс Монгол" ХХК-аас зохион байгуулсан “Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэх нь” сургалт;

Дээрх сургалтуудыг толгой компани болон төрийн эрх бүхий байгууллагууд зохион байгуулсан тул компаниас сургалтын зардал гараагүй болно.


# БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОН 25 АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Компанийн 2026 оны бизнес төлөвлөгөө нь гурван зорилго, найман зорилт, нийт 25 арга хэмжээнээс бүрдэж байна. Үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах зорилгоор арга хэмжээ тус бүрийн суурь түвшин, улирал тутмын хүрэх үр дүн, ач холбогдлын жин, шалгуур үзүүлэлт болон хэрэгжүүлэх ба хамтран ажиллах нэгжийг нарийвчлан тодорхойлсон. Гүйцэтгэлийн хувийг жилийн эцсийн үр дүнд бус, тухайн арга хэмжээний I-II улирлын төлөвлөсөн үр дүнг 100 хувь гэж үзэн тооцсон болно. Тайлант үед хугацаа нь болоогүй арга хэмжээг батлагдсан төлөвлөгөөнд тэмдэглэгдсэн байдлаар нь "-" гэж авч, жинлэсэн тооцооноос хассан бөгөөд холбогдох зорилтын үлдсэн жинг дахин хуваарилав.

## Зорилт тус бүрийн жинлэсэн гүйцэтгэл

| Зорилт | Арга хэмжээ | Жингийн нийлбэр | Жинлэсэн гүйцэтгэл |
|---|---|---|---|
| Зорилт 1.1. Барилга угсралтын шатанд шилжих бэлтгэлийг хангах | 3 | 1.00 | 56.0% |
| Зорилт 1.2. Гэрээ хэлэлцээрүүдийн төслүүдийг боловсруулах | 3 | 1.00 | 100.0% |
| Зорилт 1.3. Төсөлд хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших байр сууриа тодорхойлох | 4 | 1.00 | 90.0% |
| Зорилт 1.4. Дотооддоо байгалийн хий авч ашиглах шийдвэрийг гаргуулах | 3 | 1.00 | 80.0% |
| Зорилт 2.1. Замын-Үүдийн логистикийн төвийн судалгааг гүйцэтгэх | 3 | 1.00 | 80.0% |
| Зорилт 2.2. Экспортын борлуулалтын шинэ сувгийг нээх | 1 | 1.00 | 85.0% |
| Зорилт 3.1. Хууль эрх зүйн болон зах зээлийн судалгааг хийх | 4 | 1.00 | 89.6% |
| Зорилт 3.2. Бизнес загварыг тодорхойлох | 4 | 1.00 | 75.0% |
| **НИЙТ ГҮЙЦЭТГЭЛ** | **25** | **—** | **82.0%** |

**Зорилт тус бүрийн жинлэсэн гүйцэтгэл, хувь**




**Найман зорилтын жинлэсэн гүйцэтгэл**

*Эх сурвалж: 2026 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан; Тайлангийн хавсралт.xlsx*

Арга хэмжээ тус бүрийн төлөвлөсөн үр дүн, гүйцэтгэсэн ажил, гарсан бүтээгдэхүүн, гүйцэтгэлийн хувь, хоцролтын шалтгаан, удирдлагаас авч хэрэгжүүлсэн арга

хэмжээ болон II хагас жилд хэрэгжүүлэх арга хэмжээг энэхүү тайлан.

## Гүйцэтгэлийн шинжилгээ

*Өндөр гүйцэтгэлтэй чиглэл:* Тайлант хугацаанд төслийн хүрээнд байгуулагдах гэрээ хэлэлцээрүүдийн төслүүдийг боловсруулах зорилт (100.0%) болон төсөлд хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших байр сууриа тодорхойлох зорилт (90.0%) хамгийн өндөр гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна. Энэ нь 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Нууцлалын гэрээг байгуулж, Засгийн газар хоорондын болон Хүлээн авагч засгийн газрын гэрээний төслүүдийг боловсруулсан, төслийн санхүүгийн урьдчилсан загварыг гаргаж холбогдох байгууллагад танилцуулсан зэрэг бодит үр дүнгээр илэрчээ.

*Хамгийн бага гүйцэтгэлтэй чиглэл:* Барилга угсралтын шатанд шилжих бэлтгэлийг хангах зорилт (56.0%) хамгийн бага гүйцэтгэлтэй гарлаа. Тухайлбал, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННҮ) батлуулах, газрын эрхийн асуудлыг шийдвэрлэх, барилгын зөвшөөрөл авах зэрэг гурван арга хэмжээ нь төрийн байгууллагын шийдвэр, цаг хугацаарьтай шууд холбоотой тул тайлант хугацаанд эцсийн үр дүнд хүрээгүй байна.

*Судалгааны шатанд буй чиглэл:* Дотооддоо байгалийн хий авч ашиглах шийдвэрийг гаргуулах зорилт (80.0%) одоогоор судалгааны шатанд үргэлжилж байна. Тус чиглэлийн гурван арга хэмжээний аль нь ч эцсийн судалгааны тайлан гаргаагүй бөгөөд үүнд хүний нөөцийн бүрдүүлэлт удааширсан болон бизнес төлөвлөгөө хугацаа хоцорч батлагдсан зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлжээ.

Төлөвийн задаргаа ба тооцооллын арга: 25 арга хэмжээнээс хэрэгжсэн, хэсэгчлэн хэрэгжсэн, хоцорсон гэсэн ангилалд 10 / 11 / 1 арга хэмжээ тус тус хамаарч байна. Хугацаа нь тайлант үед болоогүй 3 арга хэмжээг жинлэсэн тооцооноос хасаж, холбогдох зорилтын үлдсэн жинг дахин хуваарилав. Хяналтын үзүүлэлт болгон жингүй энгийн дунджаар тооцвол гүйцэтгэл 82.3% буюу жинлэсэн үзүүлэлттэй ойролцоо гарч байгаа нь тооцооллын дотоод уялдааг баталгаажуулж байна.

## Хоцролтын шалтгааны бүлэглэл

| Шалтгааны бүлэг | Тайлбар ба нөлөөлсөн чиглэл |
|---|---|
| Өөрчлөн байгуулалт | Компанийн чиг үүрэг, бүтэц, орон тоо 2026 оны 02 дугаар сарын 26-ны өдөр шинэчлэгдэж, 03 дугаар сард хөдөлмөрийн харилцааны шилжилт хөдөлгөөн хийгдсэн нь үйл ажиллагаанд нөлөөлсөн. *Нөлөөлсөн чиглэл: Бүх зорилт* |
| Төлөвлөгөө орой батлагдсан | Компанийн төсөв, бизнес төлөвлөгөө 2026 оны 04 дүгээр сарын 14-нд, харин худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 04 дүгээр сарын 21-нд тус тус батлагдсан нь ажлын гүйцэтгэлд цаг хугацааны хувьд хүндрэл үүсгэсэн. |
| Хүний нөөц | Батлагдсан 45 орон тооноос 25 буюу 55.6 хувь нь л бүрдсэн нь цаг үеийн ажлууд болон судалгаа, шинжилгээний арга хэмжээ хоцрох шалтгаан болсон. *Нөлөөлсөн чиглэл: Судалгаа, шинжилгээний арга хэмжээ* |
| Мэдээллийн хүртээмж | Төслийн Санхүү, эдийн засгийн үндэслэл (СЭЗҮ) 2026 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар ирж амжаагүй байна. *Нөлөөлсөн чиглэл: Монголын талын оролцооны шийдвэрийн бэлтгэл* |
| Төрийн байгууллагаас хамаарсан | Газрын эрхийн асуудал Засгийн газрын хуралдаанд шилжсэн болон Байгаль орчны мэргэжлийн зөвлөлийн хуваарьтай холбоотойгоор шийдвэр гаргах үйл явц удааширсан. |
| Гадаад талаас хамаарсан | Оролцогч талын хувь эзэмшил тодорхойгүй; газрын тосны бүтээгдэхүүний экспортод хязгаарлалт; хил дамнасан төлбөр тооцоо шийдэгдээгүй |
| Газар, зөвшөөрөл | Замын-Үүдийн 60 га газрын эрх зүйн статус эцэслэн тодорхойгүй; зөвшөөрлийн нэгдсэн жагсаалт гараагүй |

# ДОТООДЫН ХИЙ, LNG/CNG-ИЙН СУДАЛГАА

## Дотоодод байгалийн хий хэрэглэх шийдвэр гаргуулах зорилтын хүрээнд:

Дотооддоо байгалийн хий авч ашиглах эсэх шийдвэрийг гаргуулах зорилтот ажлын хүрээнд дараах 3 арга хэмжээг төлөвлөн ажиллав. Үүнд:

1. Монгол Улсын байгалийн хийн хэрэглээний зах зээлийн системчилсэн судалгаа;
2. Хот, суурин газрын хийн хэрэглээний судалгаа;
3. Шингэрүүлсэн (LNG) болон шахсан (CNG) байгалийн хийн хэрэглээний судалгаа.

## Гүйцэтгэлийн биелэлт ба явц (80.0%):

Дээрх арга хэмжээнүүдийн хүрээнд батлагдсан судалгааны тайлан эцэслэн гараагүй бөгөөд зорилтын гүйцэтгэл 80.0 хувьтай байна. Эхний хоёр арга хэмжээний хувьд судалгааны ажил үргэлжилж байгаа бөгөөд судалгааны аргачлал болон эрэлтийн суурь мэдээллийн багц бүрэн эцэслэгдээгүй. Шингэрүүлсэн болон шахсан байгалийн хийн чиглэлээр олон улсын туршлага, технологийн шийдлийн судалгааг эхлүүлсэн боловч Монгол Улсад нэвтрүүлэх бодит загвар боловсруулагдаагүй байна.

## Техникийн суурь болон эдийн засгийн тооцоолол:

Техникийн асуудлын хүрээнд дотоодын хийжүүлэлтийн боломжийг зураг төсөлд урьдчилан тусгасан. Хийг Дархан, Улаанбаатар (2 цэг), Чойр, Сайншанд гэсэн байршил бүхий 5 хаалтын зангилаанаас авах боломжтойгоор төлөвлөсөн нь хот суурин газрын хэрэглээний судалгааны техникийн суурь болж байна. Гэсэн хэдий ч эрэлт, өртөг болон тарифын эдийн засгийн тооцоо хараахан хийгдээгүй.

## Эцсийн шалгуур үзүүлэлт:

Тус зорилтын эцсийн шалгуур үзүүлэлт болох дотоодод хий авч ашиглах эсэх шийдвэр нь Монгол Улсын Засгийн газар болон Улсын Их Хурлын түвшинд шийдвэрлэгдэх тул төслийн санхүү, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийн эцсийн үр дүнтэй шууд холбогдоно.

# ИЛ ТОД БАЙДАЛ, ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАРИЛЦАА

## Ил тод байдал

Ил тод, нээлттэй байршуулах шаардлагатай мэдээллийг компанийн цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тухай бүр байршуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт 76 мэдээллийг байршуулахаас 74 мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанд байршуулж, 2 мэдээлэл хугацаа хоцорсон байна. Хугацаа хоцрох тохиолдлыг таслан зогсоох талаар хариуцсан албан тушаалтанд чиглэл өгч ажилласан.

## Оролцогч талуудын харилцаа

Компани нь Ерөнхий сайдын 2025.12.19-ний 171 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн гурван дэд ажлын хэсэг буюу эдийн засаг; бүтээн байгуулалт; гэрээ, эрх зүйн дэд ажлын хэсгүүдийн үйл ажиллагаанд оролцож ажилласан.

Хувьцаа эзэмшигчийн хурлыг 2026.04.24-нд хийж, компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулсан. ТУЗ-ийн аудитын хорооны 2026.04.13-ны хурлаар 2026 оны төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг танилцуулж, дүгнэлт, санал, зөвлөмж авсан.

Орон нутгийн болон олон нийтийн оролцооны хувьд тайлант үед олон нийтийн сонсгол зохион байгуулагдаагүй нь гол дутагдал болж байна. Төслийн ач холбогдол, эдийн засаг, эрх зүйн үр өгөөжийг олон нийтэд танилцуулах ажлыг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалтад нийцүүлэн зохион байгуулах шийдлийг боловсруулах шаардлагатай байна.

# ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д заасан үйлчлэх хүрээнд “Эрдэнэс Газ” ХХК хамаарах бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангах үүргийг хуулиар хүлээсэн болно. Компанийн дотоод аудитын нэгж нь нэгдлийн бусад компанид илэрсэн нийтлэг зөрчлийг судалж, шинээр байгуулагдсан компанийн хувьд зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөмж боловсруулан хэрэгжүүлж ажилласан.

## Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

| Хуулийн шаардлага | Тайлант үеийн байдал | Төлөв |
|---|---|---|
| Чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоохгүй байх | 45 орон тооны хязгаараас 25 ажилтантай; хэтрэлт гараагүй; байнгын чиг үүрэгт хөдөлмөрийн гэрээ байгуулсан | Хэрэгжсэн |
| Бараа материалыг үр ашиггүй нөөцлөхгүй байх | Хангамжийн зардлын гүйцэтгэл жилийн төсвийн 41.8%; их хэмжээний нөөцлөлт хийгээгүй | Хэрэгжсэн |
| Байгууллагын хөрөнгөөр биеийн тамир, спортын уралдаан зохион байгуулахгүй байх | Ийм зориулалтаар зардал гараагүй | Хэрэгжсэн |
| Байгууллагыг сурталчлах нэвтрүүлэг, контент санхүүжүүлэхгүй байх | Зар сурталчилгааны 4 багц хэрэгжээгүй; гүйцэтгэл гараагүй | Хэрэгжсэн |
| Нэгжүүд биелэлтээ хагас жилээр тайлагнах | Дөрвөн нэгж хагас жилийн гүйцэтгэлээ тайлагнасан | Хэрэгжсэн |
| Буруутай шийдвэрээс үүссэн хохирлыг байгууллагаас төлөхгүй байх | Тайлант үед ийм зардал гараагүй | Хэрэгжсэн |
| Захирал, менежер хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахгүй байх | Тээврийн зардал 2026 оны төсөвт тусгагдаагүй | Хэрэгжсэн |
| Шилэн дансны хуулийн хэрэгжилт | 76 мэдээллээс 74-ийг хугацаанд нь байршуулж, 2 мэдээлэл хугацаа хоцорсон | Хэсэгчлэн |

Дотоод аудитын төлөвлөгөөний дагуу Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2026 оны IV улиралд хяналт хийхээр төлөвлөсөн байна.

# БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

## Байгаль орчин

Компанийн байгаль орчны чиглэлийн үндсэн үүрэг нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг эцэслэн боловсруулж, мэргэжлийн зөвлөлөөр батлуулах явдал юм. Суурь түвшинд үнэлгээний тайлан боловсруулагдсан боловч олон нийтийн хэлэлцүүлэг хийгдээгүй байсан.

Тайлант үед 67 багт олон нийтийн сонсгол зохион байгуулах урьдчилсан төлөвлөгөө боловсруулагдсан. Хойд хэсгийн сонсголыг II улиралд зохион байгуулах төлөвлөгөөт үр дүн биелээгүй байна. Хөндөгдөх сумдын олон нийтийн зөвлөлдөх сонсголыг III улиралд зохион байгуулж, газар чөлөөлөлт, нөхөн олговор, амьжиргаа сэргээх хүрээг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулахаар төлөвлөв.

Зураг төслийн баримт бичигт байгаль орчныг хамгаалах арга хэмжээний бүлэг тусгагдсан бөгөөд хоолойн шугаман хэсэг байрлах газарт барилга угсралтын дараа нөхөн сэргээлт хийж, газрыг эргэлтэд буцаан оруулах зарчмыг баримтална. Эдгээр нь барилгын шатны үүрэг бөгөөд тайлант үед хэрэгжих ажил үүсээгүй.

## Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

Компанийн үйл ажиллагаа нь оффисын нөхцөлд явагдаж, талбайн ажил нь албан томилолтын хүрээнд хязгаарлагдаж байгаа тул хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэлийн түвшин харьцангуй бага байна. Тайлант үед осол, хурц хордлого бүртгэгдээгүй.

Албан хаагчдын эрүүл мэндийн үзлэг, оношилгооны арга хэмжээ төлөвлөгдсөн боловч тайлант үед хэрэгжээгүй бөгөөд III улиралд зохион байгуулахаар төлөвлөв. Албан хаагчдын хүүхдүүдэд зориулсан арга хэмжээний хүрээнд 3,663.5 мянган төгрөгийн зардал гарсан.

Барилга угсралтын шатанд шилжихэд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа болон байгаль орчны нэгдсэн менежментийн тогтолцоог урьдчилан бүрдүүлэх шаардлагатай.

# ДҮГНЭЛТ

2026 оны эхний хагас жил нь “Эрдэнэс Газ” ХХК-ийн хувьд өөрчлөн байгуулалтын хагас жил байв. Компани Монгол Улсын Засгийн газрын 2026.02.11-ний 54 дүгээр тогтоол, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2026.02.26-ны 06 дугаар тогтоолын дагуу “Эрдэнэс Ашид” ХХК-ийн нэр, чиг үүргийг өөрчилж, “Эрдэнэс Газ” төслийн нэгжийг өөртөө нэгтгэн, шинэ дүрэм, бүтэц, 45 хүний орон тооны дээд хязгаартайгаар үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

Тайлант үеийн үйл ажиллагааны гүйцэтгэлд дараах гурван гол нөхцөл бодит нөлөө үзүүлсэн болно. Нэгдүгээрт, чиг үүрэг, бүтэц, хүний нөөцийн бүрэн шинэчлэл 2026 оны I улирлын сүүлээр явагдсан. Хоёрдугаарт, 2026 оны төсөв, бизнес төлөвлөгөө 2026.04.14-нд, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 2026.04.21-нд буюу хагас жилийн 3.5 дахь сард батлагдсан. Гуравдугаарт, батлагдсан 45 орон тооноос 25 буюу 55.6 хувь нь бүрдсэн.

## Гол ололт, амжилт

- *Эрх зүйн шинэчлэл ба шилжилт:* Компанийн оноосон нэр, дүрэм, бүтэц, орон тоо болон хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлж, төслийн нэгжийн эрх үүрэг, архив, хүний нөөцийг компанид амжилттай шилжүүлж, бүтцийн шинэчлэлийг бүрэн гүйцэд хэрэгжүүллээ.
- *Эрх зүйн орчны баталгаа:* 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр “Газопровод Союз Восток” ХХК-тай Нууцлалын гэрээ байгуулснаар компанийн зүгээс төслийн санхүү, эдийн засгийн үндэслэлийн мэдээлэлд нэвтрэх эрх зүйн боломж бүрдэв.
- *Монголын талын байр суурь бэхэжсэн:* 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Хамтарсан ажлын хэсгийн хурлаар Монголын талын байр суурь албажиж, “Эрдэнэс Газ” ХХК нь тусгай зориулалтын компанид хөрөнгө нийлүүлэх замаар төсөлд оролцох, СЭЗҮ-ийг 2026 оны 06 дугаар сард Монголын талд хүргүүлж дүн шинжилгээ хийлгэх шийдвэр гарсан.
- *Тээвэр, логистикийн чиглэлээр:* 2026 оны 05 дугаар сарын 14-нөөс 18-ны өдрүүдэд томилолтоор ажиллаж, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын шинэ гарцыг газар дээр нь үнэлж, тайланг хянан баталгаажуулсан.
- *Зах зээлийн судалгаа ба нийлүүлэлтийн хувилбар:* Нэгдлийн компаниудын түлшний хэрэглээг Өмнөд, Зүүн өмнөд, Төв-Хойд бүсийн шатахууны хэрэглээний тоон өгөгдлийг нэгтгэн шинжилж, дундын зуучлагчдаас хамааралтай өртгийг бууруулах талаар судалгааны ажил хийж гүйцэтгэсэн.
- *Санхүүгийн сахилга бат, аудитын хэрэгжилт:* 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын дөрвөн зөвлөмжөөс гурвыг бүрэн хэрэгжүүлж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлан цахим системд нийтэлснээр байнгын чиг үүрэгт хөдөлмөрийн гэрээ байгуулах зөрчлийг бүрэн арилгалаа.

## Тулгамдаж буй асуудал

- *Олон нийтийн сонсгол ба БОННҮ:* Төсөл барилга угсралтын шатанд шилжиж байгаатай холбогдуулан тайлант хугацаанд олон нийтийн сонсголыг зохион байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд төслийн оролцогч талуудын хүсэлтийн дагуу тохиромжтой хугацаанд зохион байгуулахаар товлоод байна.
- *Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл:* Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 04 дүгээр сарын 21-нд батлагдсан болон нийт төсвийн хамгийн том хувийг эзлэх оффисын түрээсийн сонгон шалгаруулалт (төлөвлөгөөний 45.9%) 06 дугаар сарын 25-нд зарлагдсан бөгөөд үр дүнг нэгтгэх шатанд байгаа тул одоогийн гүйцэтгэл 4.3 хувьтай байна.

- *Хүний нөөцийн бүрдүүлэлт:* Батлагдсан орон тооны 55.6 хувь нь одоогоор бүрдсэн бөгөөд үлдэгдэл орон тоог нөхөх нь судалгаа, шинжилгээний арга хэмжээ болон үндсэн ажлуудыг төлөвлөсөн хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэх гол нөөц болно.
- *СЭЗҮ-ийн хүлээгдэж буй байдал:* Монголын талын оролцооны шийдвэрийн суурь болох Санхүү, эдийн засгийн үндэслэл (СЭЗҮ) 06 дугаар сарын 30-ны байдлаар ТЗК-иас ирэхийг хүлээж байгаа тул оролцооны хувь хэмжээ, санхүүжилтийн бүтцийг эцэслэн шийдвэрлэх ажил III улиралд үргэлжлэхээр товлогдоод байна.
- *Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт:* Шинэ бүтэц, бүрэлдэхүүн, удирдлага болон шинэчлэгдсэн чиг үүргийн дагуу үйл ажиллагааг явуулж эхэлсэнтэй холбоотойгоор компанийн урт, дунд хугацааны стратеги төлөвлөгөөг эцэслэн батлах ажил үргэлжилж байгаа бөгөөд үүнийг баталснаар аудитын албан шаардлага бүрэн хэрэгжих нөхцөл бүрдэнэ.
- *Засаглалын баримт бичгийн баталгаажилт:* Төслийн засаглалыг хангах гол баримт бичиг болох төслийн дүрэм, эрх мэдлийн матриц, нэгдсэн эрсдэлийн бүртгэл зэрэг эрх зүйн баримтуудыг албажуулах ажил хийгдэж байна.

## Толгой компанийн дэмжлэг шаардагдах асуудал

*Хамтын ажиллагааны чиглэл тогтоох талаар:* Нэгдлийн харьяа уул уурхайн компаниудын тээвэр, логистикийн зохион байгуулалт болон түлш, шатахууны нийлүүлэлтийн талаар хамтын ажиллагааг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлж, нэгдлээс холбогдох чиглэл авах.

*Газрын эрх зүйн статусыг шийдвэрлэх талаар:* Замын-Үүд сум дахь 60 га газрын эрх зүйн статусыг Зам, тээврийн яамтай эцэслэн зөвшилцөж, компанийн эзэмшилд шилжүүлэн авах ажлыг шуурхайлахад нэгдлээс дэмжлэг авах.